МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 23 өдөр Дугаар 51 Улаанбаатар хот

"Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгаа"-г үндэсний хэмжээнд зохион байгуулах тухай"

Засгийн газрын 2011 оны 108 дугаар тогтоол, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.7, 8.1.13 дахь заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 272 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн үндэсний тандалт судалгаа"-г зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар, сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг 2017 оны хоёрдугаар улиралд багтаан тайлагнахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Я.Буянжаргал)-д даалгасугай.

3. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Судалгааны явцад хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга (Р.Оюунханд)-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

080144

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 23 өдрийн
51 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

"Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн үндэсний тандалт судалгаа"-г зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга:	Я.Буянжаргал, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Д.Наранзул, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны судалгааны зохицуулагч
Гишүүд:	П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн бодлогын Хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэсийн дарга
	Б.Батцоож, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэсийн ХДХВ, ДОХ,сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Ганцэцэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
	Т.Оюунтуяа, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны Сүрьеэгийн үндэсний лавлах лабораторийн эрхлэгч
	Б.Буянхишиг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны зөвлөх
	Б.Цолмон, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тархвар судлаач

Д.Мөнхжаргал, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны эмэнд тэсвэртэй сүрьеэгийн асуудал хариуцсан их эмч

Б.Оюунчимэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн клиникийн тасгийн эрхлэгч

Г.Гантунгалаг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн

Л.Баярмаа, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эм зүйн тасгийн эм зүйч

Ж.Нарантуяа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

С.Ганзаяа, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн сүрьеэ хариуцсан мэргэжилтэн

Э.Долгион, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Н.Наранбат, Монголын сүрьеэтэй тэмцэх холбооны ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 23 өдрийн
51 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

"Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн үндэсний тандалт судалгаа"-ны ажлын хэсгийн удирдамж

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 "Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгаа"-ны ажлын хэсэг (цаашид "ажлын хэсэг" гэх) нь судалгааг явуулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, судалгаатай холбоотой бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч байгууллагуудын ажлыг уялдуулан зохицуулах, нэгдмэл удирдлагаар хангах чиг үүрэгтэй ажиллана.
1.2 Ажлын хэсэг нь судалгааны үр дүнг захиалагч байгууллагад тайлагнана.

Хоёр. Ажлын хэсгээс явуулах үйл ажиллагаа

2.1 Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, уялдуулан зохицуулах ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь сар тутам зохион байгуулагдах ээлжит хуралдаан байна.
2.2 Ээлжит бус хуралдааныг ажлын хэсгийн дарга зарлан хуралдуулна.
2.3 Шаардлагатай тохиолдолд хуралдааныг өргөтгөсөн байдлаар хийж болно. Энэхүү өргөтгөсөн хуралд оролцогчдын бүрэлдэхүүнийг ажлын хэсгийн дарга тогтооно.
2.4 Хурлаар хэлэлцэх асуудлыг ажлын 5 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.
2.5 Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааг зохион байгуулах ажлын хэсгийн хуралдаан нь судалгааны бэлтгэл ажил болон мэдээлэл цуглуулах ажлын явц, байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, ажлын үр дүнг сайжруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар санал солилцож, хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
2.6 Ажлын хэсгийн дарга бөгөөд ЭМБХЗГ-ын НЭМХ-ийн дарга хурлыг удирдан явуулна. Ажлын хэсгийн даргын эзгүйд ХӨСҮТ-ийн халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал хурлыг удирдан хийнэ.

Гурав: Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх асуудал

3.1. Ажлын хэсгийн гишүүдийн хариуцах ажлын чиглэл, хуваарийг хэлэлцэж батлах, дүгнэх
3.2. Судалгааны протокол боловсруулахад зөвлөгөө өгөх, биечлэн оролцох

3.3. Судалгаанд шаардлагатай санхүүжилт, тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх
3.4. Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл боловсруулах, урьдчилсан судалгаа, сургалт хийхэд мэргэжил арга зүйн туслалцаагаар хангах
3.5. Судалгааны явцыг сар бүр хэлэлцэж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх
3.6. Судалгааны багийн улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх
3.7. ДЭМБ болон олон улсын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд оролцох
3.8. Судалгааг зохион байгуулах, уялдуулан зохицуулахтай холбоотой аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хорих 429-р анги, Энэрэл эмнэлгийн удирдлагуудтай уулзах, санал солилцох, дэмжлэг авах
3.9. Аймаг, дүүрэгт мэдээлэл цуглуулах ажлын явцад хөндлөнгийн хяналт хийж, үнэлгээ дүгнэлт гаргах
3.10. Бусад тулгамдсан асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх

Дөрөв. Хуралдааны бэлтгэл хангах

4.1. Хурлыг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны судалгааны багаас зохион байгуулна.
4.2. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг ажлын хэсгийн дарга батална.
4.3. Хурлаар хэлэлцүүлэх материалыг хурал хийхээс 5 хоногийн өмнө ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн байна.
4.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан ажлын хэсгийн даргаар хянуулж батлуулна.
4.5. Хурлын шийдвэрийн төслийг тухайн асуудал оруулж байгаа мэргэжилтэнүүд боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудын саналыг авсан байна.
4.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын батлагдсан төлөвлөгөө, хуралд хэлэлцүүлэх материалуудыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд батлагдсан даруйд и-мэйл хаягаар хүргүүлнэ.
4.7. Хурлыг өргөтгөн зохион байгуулж байгаа үед гаднаас орох хүмүүсийн нэрсийн жагсаалтыг нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн даргад танилцуулж батлуулна.

Тав. Хуралдаан зохион байгуулах, шийдвэр гаргах

5.1. Ажлын хэсгийн дарга тухайн өдрийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг танилцуулж, төлөвлөгөөнд орсон дараалын дагуу хэлэлцүүлнэ.
5.2. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга өмнөх хурлаас гаргасан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцад хяналт тавьж энэ талаарх мэдээллийг бэлтгэн хийнэ.
5.3. Судалгаатай холбоотой хэлэлцэж байгаа асуудалд холбогдох зураг, видео бичлэг, биет зүйлс, түүний загвар, хэсгийг хурал дээр үзүүлж болно.
5.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлын явцын талаарх тэмдэглэлийг бичнэ.
5.5. Хурлын тэмдэглэлийг ажлын хэсгийн даргад хянуулан гарын үсэг зуруулж баталгаажуулна.

5.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад шуурхай хүргэнэ.

Зургаа. Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих

6.1. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга буюу судалгааны зохицуулагч нь хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт хийж упирап тутам ажлын хэсгийн хуралд танилцуулна.

Долоо. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааг гүйцэтгэх байгууллагуудын үүрэг

7.1 Халдварт өвчин судлалын үндэсний төв.

7.1.1 Сүрьеэгийн тандалт судалгааны албаны судалгааны баг өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
7.1.2 Судалгааг явуулахад шаардагдах лабораторийн оношлуур, урвалж бодис, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах
7.1.3 Судалгаагаар илэрсэн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлыг эмчлэх эмийн нөөцийг бүрдүүлэх, тасралтгүй хангах
7.1.4 Судалгааны протоколийг боловсруулж, ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтнүүдийн саналыг тусган Техникийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэх
7.1.5 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалаар судалгааг гүйцэтгэх
7.1.6 Эрүүл мэндийн спортын яамны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороогоор хэлэлцүүлэн судалгааг явуулах ёс зүйн зөвшөөрлийг гаргуулах
7.1.7 Сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны стандарт удирдамж боловсруулан, судлаачдыг сургах, ур чадвар эзэмшүүлэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах
7.1.8 ДЭМБ болон олон улсын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, тэднээс ирүүлсэн тайлан, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
7.1.9 Судалгаанд хамрагдах аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Хорих 429 дүгээр анги, Энэрэл эмнэлгийн бэлтгэлийг сайтар хангуулах
7.1.10 Судалгааг явуулах төлөвлөгөө боловсруулан Эрүүл мэнд спортын яамаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх
7.1.11 Судалгааны протокол, хэрэглэгдэх тоног төхөөрөмж, мэдээлэл цуглуулах хэрэгсэлийн тохиромжтой байдлыг үнэлж, сайжруулах арга хэмжээ авахын зэрэгцээ мэдээлэл цуглуулах боломжтой цаг хугацааны төлөвлөлт хийсний дараа үндсэн судалгааг эхлүүлэх
7.1.12 Судалгааны нэгжүүдэд мэдээлэл цуглуулах ажлын явцын байдалд хяналт хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг, удирдлагаар хангаж ажиллах
7.1.13 Судалгааны сорьцонд түрхэц, хайн тест, өсгөвөрлөх болон эмэнд мэдрэг чанарын шинжилгээ хийж, хариуг эргэн мэдээлэх
7.1.14 Судалгааны протоколд заагдсаны дагуу лабораторийн гадаад, дотоод чанарын хяналтыг гүйцэтгэх

7.1.15 Судалгааны нэгжүүдийн цэрний сорьц тээвэрлэх зардлыг сар, улирлаар тооцох, шаардлага хангасан санхүүгийн баримтыг хүлээн авч Глобаль сангийн Хөтөлбөр зохицуулах нэгжид хүргүүлэх

7.1.16 Судалгааны баг мэдээ тайланг хянах, үнэлэх, нэгтгэх ажлыг өдөр тутам хариуцан ажиллах

7.1.17 Судалгааны бэлтгэл үе болон судалгааны явцад эсвэл мэдээллийн менежментийн үед гарсан аливаа тулгамдсан асуудлыг хугацаа алдахгүй мэдээлэх, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

7.1.18 Судалгааны мэдээллийг оруулах, цэгцлэх, хадгалах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих, үр дүнг танилцуулах, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэх

7.2 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв, Энэрэл эмнэлэг.

7.2.1 Судалгааг харъяа орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан ажиллах

7.2.2 Судалгааны протокол, үйл ажиллагааны стандарт удирдамжийг баримтлан ажиллах

7.2.3 Орон нутгийн хэмжээнд судалгаанд сонгогдсон өвчтнийг бүрэн хамруулах, түүврийн хэмжээнд хүргэх

7.2.4 Өмнө нь эмчлэгдсэн сүрьеэгийн тохиолдлын эмчилгээний түүхийг холбогдох материалаас шалгаж, баталгаажуулах

7.2.5 Судалгааны протоколийн дагуу цуглуулсан цэрний сорьцыг хугацаанд нь ХӨСҮТ-ийн СҮЛЛ-т хүйтэн хэлхээний горимын дагуу хүргүүлэх

7.2.6 ХӨСҮТ-ийн СҮЛЛ-т илгээсэн цэрний сорьцын шинжилгээний хариуг 7 хоног тутам авах

7.2.7 Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн тохиолдлын менежментийг зохион байгуулах

7.2.8 Судалгаагаар илэрсэн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол бүрийг эмчилгээнд бүрэн хамруулах, эмчилгээний үр дүнг үнэлж, тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд ирүүлэх

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 23өдрийн
51 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн үндэсний тандалт судалгааг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө (2015-2017 он)

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		2015 он, улиралаар		2016 он, улирлаар				2017 он улирлаар		Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
		III	IV	I	II	III	IV	I	II		
Нэг. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны бэлтгэл хангах талаар											
1.1	Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг томилох, тушаал гаргуулах									Б.Пунцаг, ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Б.Батцоож, ЭМБХЗГ-ын НЭМХ-ийн ХДХВ, ДОХ,Сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
1.2	Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны протоколийг боловсруулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч С.Ганзаяа, Глобаль сангийн сүрьеэгийн төсөл хариуцсан мэргэжилтэн Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх	Ажлын хэсгийн гишүүд
1.3	Судалгааны протоколийг ажлын хэсгээр хэлэлцүүлэх, санал авах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх	Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
1.4	Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгслийг урьдчилан сорил хийж сайжруулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх
1.5	Судалгааны протоколийг хянах, англи хэл рүү хөрвүүлэх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Ж.Нарантуяа, ДЭМБ-ын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн

1.6	Судалгааны протоколийг ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтнээр хянуулах, санал авах									Ж.Нарантуяа, ДЭМБ-ын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч
1.7	ХОСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар судалгааны протоколийг хэлэлцүүлэх, эрдэмтдийн саналыг тусгах, сайжруулах, батлуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач С.Ганзаяа, Глобаль сангийн сүрьеэгийн төсөл хариуцсан мэргэжилтэн	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх
1.8	ЭМСЯ-ны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар судалгааны протоколийг хэлэлцүүлж, судалгаа явуулах ёс зүйн зөвшөөрөл гаргуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч С.Ганзаяа, Глобаль сангийн сүрьеэгийн төсөл хариуцсан мэргэжилтэн	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
1.9	ХӨСҮТ-ийн судалгааны багийн гишүүдийг протоколийн дагуу сургалтанд хамруулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
1.10	Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгаанд хамрагдах нэгжүүдийн сүрьеэгийн зохицуулагч нарт сургалт зохион байгуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн Сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
1.11	Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгаанд хамрагдах нэгжүүдийн сүрьеэгийн лаборант нарт сургалт зохион байгуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн Сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх

1.12	Судалгааанд шаардлагатай лабораторийн урвалж бодис, тоног төхөөрөмжийг хүлээн авах, бэлтгэл хангах									Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч	Б.Пунцаг, ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга С.Ганзаяа, Глобаль сангийн сүрьеэгийн төсөл хариуцсан мэргэжилтэн
1.13	Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл, зураасан кодыг хэвлүүлэх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн
1.14	Судалгааанд оролцогчдод зориулсан мэдээлэл, сурталчилгааны материал бэлтгэж, хэвлүүлэх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн
Хоёр. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааанд хамрагдах нэгжүүдийн бэлтгэл хангах үйл ажиллагааны талаар											
2.1 Улаанбаатар хотын дүүргүүдэд судалгааны бэлтгэл хангах талаар											
2.1.1	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	БЗД-ийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.2	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	БГД-ийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.3	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч

2.1.4	Хан-уул дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	ХУД-ийн Эрүүл мэндийн төвийн дарга Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.5	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	СБД-ийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.6	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.7	Сонгинохайрхан дүүрийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	СХД-ийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.8	Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансерийн бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.1.9	Хорих 429-р ангийн судалгааны бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Хорих 429 -р ангийн Ерөнхий эмч, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч

2.1.10	Энэрэл эмнэлгийн судалгааны бэлтгэл ажлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Энэрэл эмнэлгийн дарга, Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч
2.2 Аймгуудад судалгааны бэлтгэл хангах талаар											
2.2.1	Архангай, Булган, Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Архангай, Булган, Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба
2.2.2	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба
2.2.3	Завхан, Өвөрхангай, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Завхан, Өвөрхангай, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба
2.2.4	Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба

2.2.5	Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба
2.2.6	Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба
2.2.7	Говьсүмбэр, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансертай судалгааны бэлтгэл ажлыг хангуулах телеконференц хийх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Говьсүмбэр, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, ХӨСҮТ-ийн Мэдээлэл технологийн алба
2.3 Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны явцад хяналт хийх талаар											
2.3.1	Улаанбаатар хотын 9 дүүрэг, Энэрэл эмнэлэг, Хорих 429-р ангийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх									Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч	Б.Пунцаг, ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач
2.3.2	Судалгаанд хамрагдах 21 аймгийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх									Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Д.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны Үзлэг хяналтын тасгийн эрхлэгч	Б.Пунцаг, ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач
Гурав. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны мэдээллийн менежментийн талаар											
3.1	Судалгааны мэдээллийг оруулах, нэгдсэн сан үүсгэх талбарыг бэлтгэх									Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч

3.2	Судалгааны мэдээллийг хадгалах, найдвартай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх									Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
3.3	Судалгааны мэдээллийг өдөр тутам оруулах, цэгцлэх, шалгах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
3.4	Судалгаагаар илэрсэн тохиолдлын менежментийн зохицуулалтыг өдөр тутам хийх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
3.5	Судалгаагаар илэрсэн тохиолдлыг эмнэлзүйн багийн хурлаар хэлэлцүүлэх, эмч нарын хамтарсан зөвлөгөөнд бэлтгэх									Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач Д.Мөнхжаргал, ХӨСҮТ-ийн СТСА-ны их эмч	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
3.6	Судалгаагаар илэрсэн тохиолдлын эмчилгээний үр дүнг дагаж судлах, үр дүнг тайлагнах									Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач Д.Мөнхжаргал, ХӨСҮТ-ийн СТСА-ны их эмч	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч
3.7	Судалгааны мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийхэд ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтэн урьж ажиллуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Ж.Нарантуяа, ДЭМБ-ын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
3.8	Судалгааны үр дүнгийн нэгдсэн тайлан бичих									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх Ажлын хэсгийн гишүүд
3.9	Судалгааны үр дүнгийн тайланг хянуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Ажлын хэсгийн гишүүд

3.10	Судалгааны үр дүнгийн тайлан оруулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Ж.Нарантуяа, ДЭМБ-ын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
3.11	Судалгааны үр дүнгийн тайланг монгол, англи хэлээр хэвлүүлэх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн
3.12	Судалгааны үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн	Ажлын хэсгийн гишүүд
3.13	Олон улсын сэтгүүлд судалгааны үр дүнг нийтлүүлэх									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Б.Цолмон, ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач	Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч Б.Буянхишиг, ХӨСҮТ-ийн СТСА-ны зөвлөх
3.14	Судалгааны мэдээллийн нэгдсэн сан үүсгэж архивлах, хадгалах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч	Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн
Дөрөв. Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгааны хүний нөөц, санхүүжилтийн менежментийн талаар											
4.1	Сүрьеэгийн тархалтын судалгааны талбарт мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтэн урьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авах									Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч	Ж.Нарантуяа, ДЭМБ-ын ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Ганзаяа, Глобаль сангийн сүрьеэгийн төсөл хариуцсан мэргэжилтэн
4.2	Аймаг, дүүргээс судалгаанд оролцогчийн цэрний сорьц зөөвөрлөсөн зардлыг тухай бүр тооцож, санхүүгийн тайлан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн	Д.Наранзул, ХОСҮТ-ийн судалгааны зохицуулагч

4.3	Судалгааны явцад сүрьеэгийн лабораторт нэмэлтээр ажиллах хүний нөөцийг судлаж авах, гэрээ байгуулах									Т.Оюунтуяа, ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-ийн эрхлэгч	Б.Пунцаг, ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч
4.4	Аймаг, дүүрэгт судалгааг гардан зохион байгуулж буй судалгааны багийн ахлагчийн урамшуулалыг тооцох, олгох									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн	Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч
4.5	Судалгаанд шаардлагатай санхүүжилтийг цаг тухайд тооцож төлөвлөх, тайлан мэдээг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх									Г.Гантунгалаг, ХӨСҮТ-ийн сорьц тээвэрлэлтийн дэд төсөл хариуцсан мэргэжилтэн	Д.Наранзул, ХӨСҮТ-ийн судалгааны зохицуулагч